



**ПАРА ТАЕКВОНДОГИЙН  
УАШТ  
2023**

**2023.12.18-19**

**СПОРТЫН ТӨВ ОРДОН**

[www.mongol-taekwondo.com](http://www.mongol-taekwondo.com)

**БАТЛАВ**  
“МОНГОЛЫН ТАЕКВОНДОГИЙН ХОЛБОО”  
ГҮТББ-ЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Б.ОНОН

**“ПАРА ТАЕКВОНДОГИЙН 2023 ОНЫ  
МОНГОЛ УЛСЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНИЙ”-ИЙ ЗААВАР**

**ТЭМЦЭЭНИЙ ЗОРИЛГО:**

- Таеквондогийн спортыг сурталчлах,
- Монгол улсад олимпын таеквондогийн спортыг түгээн дэлгэрүүлэх, гарны бэрхшээлтэй хүүхэд залуучуудад таеквондогийн спортоор хичээллэх ач тусыг таниулах.
- Баг тамирчдын ур чадварыг дээшлүүлж, харилцан туршлага солилцох.

**ЗОХИОН БАЙГУУЛАГЧ:**

<b>Зохион байгуулагч</b>	Монголын таеквондогийн холбоо
<b>Холбоо барих утас</b>	7015-5500, 8619-0073
<b>Имэйл</b>	mongoliatekwondo@gmail.com
<b>Нийгмийн сүлжээ</b>	<a href="https://www.facebook.com/MongolTaekwondo">https://www.facebook.com/MongolTaekwondo</a> ,
<b>Хаяг</b>	Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 8-р хороо, Спортын төв Ордон

**ТӨЛӨВЛӨГӨӨТ ХУВААРЬ:**

Огноо	Хөтөлбөр	Байршил
<b>2023.11.27-оос 2023.12.8 хүртэл</b>	Бүртгэл	www.mongol-taekwondo.com
<b>12 сарын 15</b>	Техникийн зөвлөгөөн	Таеквондогийн үндэсний шигшээ багийн заал
<b>12 сарын 17</b>	Жин үзэлт	Таеквондогийн үндэсний шигшээ багийн заал
<b>12 сарын 18-19</b>	Тэмцээн	Спортын төв Ордон, А заал

- ❖ Бүртгэл хаагдсаны дараа тэмцээний дэлгэрэнгүй хуваарь нийтэд зарлагдах ба тэмцээнд оролцогчдын тооноос хамаарч өдөрт өөрчлөлт орж болзошгүй.
- ❖ Бүртгэл хаагдсаны дараа оролцогч тамирчдын жин үзүүлэх байршил болон хугацааг олон нийтэд мэдээлнэ. (оролцогч байгууллагуудын бүсчлэл, оролцогчдын тоог харгалзан үзнэ)

## ТЭМЦЭЭНИЙ ЗААВАР:

### 1. ТЭМЦЭЭНД ОРОЛЦОГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА:

- Оролцогч тамирчин нь Монголын таеквондогийн холбоо болон Күккивоны ямар нэг зэрэг, дантай байна, зөвхөн тэр бүсээ бүсэлж өрсөлдөнө.
- Нэг байгууллагаас орох тамирчны тоонд хязгаарлалт тавихгүй.
- Тамирчдын жинг олон кг-р хасахгүй байхыг нийт багш, дасгалжуулагч нарт онцгой анхааруулж байна
- Тэмцээнд оролцох тамирчид Монголын таеквондогийн стандартад нийцсэн өмсгөл өмсөн тэмцээнд оролцох шаардлага тавигдана



- Тулаан Daedo цахим хамгаалах систем дээр явагдана.
- Шүдний хамгаалалтын хувьд өнгөгүй тунгалаг эсвэл цагаан өнгөтэйгөөс бусад өнгөтэй шүдний хамгаалалт зүүхийг хориглоно.
- Шигшээ тулааны үеэр дасгалжуулагчид албаны хувцас /костюм/ өмсөх шаардлагатай.

## 2. ТУЛААН /ЖИНГИЙН ДАРААЛАЛ/

Пара /17-оос дээш нас/:

Эр		Эм	
- 63кг	63кг хүртэлх	- 52кг	52кг хүртэлх
+ 63кг	63кг жингээс дээш жинтэй тамирчид	+ 52кг	52кг жингээс дээш жинтэй тамирчид

- ❖ Жин тус бүрт заасан жиндээ багтаж орох хэрэгтэй ба заасан жингээс 100гр илүү жинтэй байх тохиолдолд жиндээ орж чадахгүй хасагдана. Жиндээ орж чадаагүй тамирчин дээд жиндээ орж болохгүй буюу зөвхөн мэдүүлэгт өгсөн жиндээ орох

## 3. ОРОЛЦОГЧИЙН ХУРААМЖ

Тэмцээнд оролцогч нэг тамирчны дэвжээний төлбөр дэвжээний төлбөр 50,000 (тавин мянга)-н төгрөг

**Оролцогчийн хураамж хүлээн авах данс:**

Банк: Хаан банк

Хүлээн авагч: Монголын Таеквондогийн холбоо

Дансны дугаар: 5431161905

## 4. ТЭМЦЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН ГАРГАХ

- Тэмцээнийг ДТХ-ны дүрмийн дагуу хасагдах системээр явуулж, 1-р байр нэг, 2-р байр нэг, 3-р байр хоёр тамирчин шалгаруулан шагнаж урамшуулна.

## 5. ШАГНАЛ УРАМШУУЛАЛ

- Жиндээ эхний 3 байр эзэлсэн тамирчдыг алт, мөнгө, хүрэл медаль, өргөмжлөлөөр шагнаж урамшуулна.

- ТЭМЦЭЭН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХОРОО -